

**БАТЛАВ:
УИХ-ЫН ГИШҮҮН**

Ц.БААТАРХҮҮ

2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

**ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын 9 дүгээр зүйлд "Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, төрийн санхүүг удирдах"-ыг ил тод, нээлттэй, үр ашигтай байлгах тогтолцоог бүрдүүлэх үүргийг гишүүн орнуудад хүлээлгэсэн. Олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр мөрдөгдөх Үндсэн хуулийн зарчмын дагуу Шилэн дансны мэдээллийн босгыг бууруулж, ил тод байдлыг олон улсын жишигт хүргэх нь тус конвенцын заалтыг амьдралд хэрэгжүүлэх эрх зүйн арга хэмжээ юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь заалтаар иргэн "төр, түүний байгууллагаас хууль ёсоор нууцалсанаас бусад асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх"-ийг баталгаажуулсан. Уг төслийн 1, 2 дугаар зүйлээр мэдээлэх босго үнийг бууруулж, олон улсын стандартад шилжүүлж байгаа нь иргэний Үндсэн хуулиар олгогдсон мэдээлэл авах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг бодит үйл ажиллагаа болгох хууль зүйн суурь шаардлага юм.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэлийн 5.1-д "Авлигыг бууруулж, иргэдийн шүүхэд итгэх итгэл, шударга ёсны тогтолцоог бэхжүүлж, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлж, батлан хамгаалах, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулж, "Цахимаар түрүүнд" зарчмыг хэрэгжүүлж, иргэн төвтэй үйлчилгээг бүрдүүлж зөв засаглалын үзүүлэлтээр эхний 90 орны нэг болно" гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөр"-ийн 4.1.4.1.-д "Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно" гэж заасан.

1.2. Практик шаардлага

Шилэн дансны тухай хууль 2014 онд батлагдсанаас хойш 12 жилийн хугацаа өнгөрсөн байна. Энэ хугацаанд хуулийн хэрэгжилт хэлбэр төдий, шилэн дансны мэдээлэл ойлгомжгүй, иргэд шилэн дансны цахим хуудаснаас мэдээлэл авахад ойлгомжгүй, хүндрэлтэй асуудал цөөнгүй тулгардаг талаар иргэний нийгмийн байгууллагуудын санал болон хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайланд тусгажээ.

“Транспаренси Интернэшл” олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг Авлигын хөгжлийн индексийн оноогоор 182 орноос Монгол Улс 2017 онд 36 оноо авч 103, 2018 онд 37 оноо авч 93, 2019 онд 35 оноо авч 106, 2020 онд 35 оноо авч 111, 2021 онд 35 оноо авч 110, 2022 онд 33 оноо авч 116, 2023, 2024 онд 33 оноо авч 121, 2025 онд 124 дүгээр байрт тус тус эрэмбэлэгджээ.

Шилэн дансны тухай хуулийн зохицуулалтаар 5-10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээ, гэрээг мэдээлдэг байсан нь төсвийн хөрөнгийн үр ашиггүй жижиг зарцуулалтуудыг хянах боломжийг хязгаарлаж байв. Босго дүнг 1-3 сая төгрөг болгон бууруулснаар төсвийн үрэлгэн байдлыг хумих эрх зүйн орчин бүрдэнэ.

Шилэн дансны тухай хууль анх батлагдах үеийн мөнгөний ханш, төсвийн байгууллагуудын жижиг худалдан авалтын үнийн дүн өнөөгийн практикт өөрчлөгдсөн. Төсвийн хөрөнгийг 5 сая болон 10 сая төгрөгөөс доош дүнгээр олон хувааж, хяналтаас бултах замаар "шилэн дансны" хяналтыг сулруулах зөрчил бодит нөхцөл байдал дээр дээр их гарч байна. Иймд хуулийн зохицуулалтыг амьдралд нийцүүлж, босго үнийг 1 сая болон 3 сая төгрөг болгон хуульчлах практик шаардлага үүссэн.

Шилэн дансны тухай хуулийн тодорхой зохицуулалт нь орчин үеийн хэрэгцээ, технологид нийцэхгүй, хяналт, хариуцлагын механизм сул байсаар байна.

Нээлттэй нийгэм форумаас 2023 оны 3 дугаар сард Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгад өгсөн санал шүүмжид Шилэн дансны тухай хуулийн дагуу, одоо мөрдөгдөж буй журам ёсоор иргэд шилэн дансны цахим хуудаснаас мэдээлэл авахад ойлгомжгүй, хүндрэлтэй асуудал цөөнгүй тулгардаг талаар иргэний нийгмийн байгууллагуудын санал болон хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайланд тусгагджээ. Тиймээс цахим хуудас дахь мэдээллийн төрлийг сайжруулах, формат, татаж авах боломжийг хангах зохицуулалтыг Шинэчилсэн найруулгын төсөл болон журам, нийтлэг стандартад тусгуулах, нэгдсэн системийн хөгжүүлэлт, шинэчлэл хийх саналыг гаргасан байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь төсвийн хөрөнгийн зарцуулалт, худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэнэ. Шилэн дансанд мэдээлэх гүйлгээ, худалдан авалтын мөнгөн дүнг багасгаж, худалдан авалтын мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэн нээлттэй болгох журмыг тодорхойлно:

1. Шилэн дансанд мэдээлэх худалдан авалтын дүнгийн босго үнийг нэг сая болон гурван сая төгрөг болгож багасагах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.
2. Төсвийн хөрөнгийн зарцуулалт, худалдан авалтын мэдээллийг олон улсын стандарт нийцүүлэх зорилгоор нээлттэй гэрээний олон улсын стандартыг нэвтрүүлнэ.
3. Шилэн дансны мэдээллийг шуурхаа байршуулах, мэдээлэл оруулагчийн ажлыг хялбарчлах зорилгоор холбогдох системийн мэдээллийг ашиглах зохицуулалтыг тусгана.
4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих этгээдийг тодорхой болгож, давхардсан чиг үүргийг өөрчилнө.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар шилэн дансны мэдээллийн нээлттэй ил тод байдал сайжирч, иргэдийн төрд итгэх итгэл дээшилж улмаар авлигын эрдсэл буурна. Мэдээлэх албан тушаалтны ажлын ачаалал бодитоор буурч, шилэн дансны мэдээлэл ойлгомжтой болсноор иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрх баталгаажина.

Шилэн дансны тухай нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловрсуулж баталснаар дараах үр дүнд хүрнэ гэж тооцож байна:

- 1) Авлигын эсрэг конвенцид заасан үүргийн хэрэгжилт хангагдаж, төсвийн зарцуулалтын ил тод байдал дээшилнэ;
- 2) Шилэн дансны мэдээллийг олон улсын жишигт нийцсэн стандартын дагуу нийтлэх боломж бүрдэнэ;
- 3) Шударга бус өрсөлдөөн буурч, тендерт оролцогчийн тоо нэмэгдснээр авлиггүй худалдан авалтын хэмнэлт бий болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн болосвруулсан бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.